



Өдөр бүр уулзах үндэсний
шилдэг компани



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
2018 он



Фото зургийг **Төгөл**
Увс, Цагаан дэглий уулнаас

**“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН 2018 оны
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**



Гарчиг

I. МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭНД 13

1.1. Хүний нөөцийн талаар 14

1.2. Нийгмийн асуудлын талаар 15

1.3. Олон нийтийн үйл ажиллагааны талаар 15

ХОЁР. ШУУДАНГИЙН СҮЛЖЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ, ТЕХНОЛОГИЙН ТАСРАЛТГҮЙ ХЭВИЙН АЖИЛЛАГААГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД 17

2.1. Шуудан солилцооны бүртгэл, судалгааны талаар 18

2.2. Хүргэлтийн чиглэл, маршрутыг оновчтой зохион байгуулах,
үр ашигтай болгох талаар 19

2.3. Шуудангийн гардуулалтын талаар 19

2.4. Хэрэглэгчийн үйлчилгээг хариуцан, гомдол, хохирлыг барагдуулах талаар 20

ГУРАВ. ШУУДАНГИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ, ИДЭВХЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД 24

3.1. Компанийн өнгө төрхийг шинэчлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах, олон нийтэд таниулах талаар 25

3.2. Өдөрлөг, ICT Expo 2018, Хур нэгдсэн системийн талаар 26

3.3. Шуудангийн үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг идэвхжүүлэх талаар 28

ДӨРӨВ. ТЭЭВЭР ЗУУЧ, ЛОГИСТИКИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД 29

- 4.1. Транзит шуудангийн үйл ажиллагааг сайжруулах, шинээр суваг нээх талаар 30
- 4.2. Дотоод логистикийн үйлчилгээг өргөжүүлэх талаар 30
- 4.3. Гаалийн зуучлалын үйлчилгээг эхлүүлэх талаар 31
- 4.4. Ялган боловсруулах төвийг байгуулах бэлтгэл ажлыг хангах талаар 31

ТАВ. МАРК, ҮНЭТ ЦААС 32

- 5.1. Маркийн үүсэл хөгжил 33
- 5.2. Мэдээллийн технологийн талаар 38

II. ХАВСРАЛТ**САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД** 40

- 1. Компанийн санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүд 41
- 2. Аудитийн тайлан 48

МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт харилцагчид, түнш байгууллагууд, хувьцаа эзэмшигчид болон хамтран ажиллагсад аа!

Монгол Шуудангийн хувьд 2018 он санхүү, эдийн засгийн тогтвортой өсөлтөө нэмэгдүүлсэн, нийгмийн хариуцлагын хүрээнд олон ажлыг хэрэгжүүлсэн, үйл ажиллагаандаа томоохон дэвшлийг дагуулсан жил байлаа.

Бид дэлхийн жишигт нийцсэн шуудангийн үйлчилгээг харилцагчдадаа хүргэх зорилгоор “Технологийн шинэчлэл, Байгууллагын соёлын шинэчлэл, Бүтээгдэхүүн үйлчилгээний шинэчлэл-2021” стратегийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна

Монгол Улсын шуудангийн салбарынхаа хөгжилд хурд, шинэчлэлийг нэмж ирсэн. 2018 онд ч энэхүү амжилтаа бататган ажилласан юм.

Харилцаа холбоо, техник технологийн хурдацтай хөгжил нь харилцагчдыг уламжлалт шуудангийн үйлчилгээнээс дижитал бүтээгдэхүүн үйлчилгээ рүү хөтөлж байна. Иймд гибрид шуудан, улс хоорондын транзит шуудангийн үйлчилгээг өргөжүүлж, дотоодын логистик үйлчилгээний чиглэлийг нэмэгдүүлж, шуудангийн ялган боловсруулах төвийг шинээр бий болгож, хүргэлтийн шинэ технологи нэвтрүүллээ.

Монгол Шуудан нь 2018 онд алсын хараагаа “Өдөр бүр уулзах үндэсний шилдэг компани” хэмээн тодорхойлсон. Энэхүү зорилтод хүрэхийн тулд шууданчдаа мэдлэг боловсрол, сургалтаар тасралтгүй хөгжүүлэхийн зэрэгцээ салбарын өнгө төрх, автомашины парк шинэчлэл хийлээ.

Эрхэм хүндэт харилцагчид, хамтран ажиллагсад, түншүүд, шууданч та бүхэндээ бидэнд итгэл хүлээлгэн, хамтран ажиллаж ирсэнд гүн талархал илэрхийлье.

Монгол Шуудангийн мянга гаруй шилдэг шууданчид, харилцагч бүрийнхээ амжилтын төлөө нэр төртэйгээр хичээнгүйлэн ажиллах болно. Мөн өөрийн ажилдаа чин сэтгэл, өндөр мэдлэг боловсрол, хичээл зүтгэлээ зориулан ажилладаг нийт Шууданчдаа халуун талархлаа илэрхийлье.

Эрхэм та манай компанийн 2018 оны жилийн тайланг минь хүлээн авна уу.

Хүндэтгэсэн:

Гүйцэтгэх захирал
Б.АНХБААТАР

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд



Д.НАРАНГЭРЭЛ

ТУЗ-ийн дарга
ТӨБЗГ-ын ахлах
мэргэжилтэн



Д.ДЭЛГЭРМАА

ТУЗ-ийн гишүүн
ТӨБЗГ-ын
мэргэжилтэн



Ч.ЭРДЭНЭЧИМЭГ

ТУЗ-ийн гишүүн
ЗГХЭГ-ын
референт



О.ОДБАЯР

ТУЗ-ийн гишүүн
“Эрдэнэс монгол”
ХХК-ийн дэд захирал



М.ХАЛИУНБАТ

ТУЗ-ийн хараат бус гишүүн
“Монгол Айдия” группийн
гүйцэтгэх захирал



С.МӨНГӨНЦЭЦЭГ

ТУЗ-ийн гишүүн
СЯ-ны ТЗУГ-ын СЗБХ-ийн
дарга



Ч .ГАНХУЯГ

ТУЗ-ийн гишүүн
Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн
гүйцэтгэх захирал



Б.АМАРСАНАА

ТУЗ-ийн хараат бус гишүүн
“МПЭ” ХХК-ийн гүйцэтгэх



Д .БАЛДОРЖ

Хараат бус гишүүн



“МОНГОЛ ШУУДАН” ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны тайлан

“МОНГОЛ
ШУУДАН” ХК нь 2018
ОНД ХЭРЭГЛЭГЧИЙН ХЭРЭГЦЭЭ
ШААРДЛАГЫГ БҮРЭН ХАНГАСАН
БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ
ЗАМААР ШУУДАНГИЙН УЛАМЖЛАЛТ НЭР ТӨРЛИЙН
БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН ҮР
ӨГӨӨЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, ШУУДАНГИЙН БАЙГУУЛЛАГЫН
ШИНЭ ӨНГӨ ТӨРХИЙГ ТОДОРХОЙЛЖ, ОРЧИН ҮЕИЙН
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ШУУДАНГИЙН
ҮНДСЭН СҮЛЖЭЭГ ӨРГӨТГӨХ, ДОТООДЫН БОЛОН ОЛОН
УЛСЫН ТЭЭВЭР ЗУУЧ, ТРАНЗИТ ТЭЭВЭР, ЛОГИСТИКИЙН
ҮЙЛЧИЛГЭЭГ ӨРГӨЖҮҮЛЭХ, ШУУДАНГИЙН ҮНДСЭН
СҮЛЖЭЭГ АШИГЛАН, САНХҮҮГИЙН НЭГДСЭН
ҮЙЛЧИЛГЭЭГ ЭХЛҮҮЛЭХ ГЭСЭН ЗОРИЛТУУДЫГ
ДЭВШҮҮЛЭН ДАРААХ ЧИГЛЭЛИЙН
ХҮРЭЭНД АЖИЛЛАЛАА.

**ОНЦЛОХ ҮЙЛ
ЯВДЛЫН
ТОВЧООН**

2018 он



ТРАНЗИТ ШУУДАН

Транзит тээврийн үйлчилгээг автомашинаар нийт **235** удаа, Бээжин-Улаанбаатар-Москва чиглэлд ачааны Бойнг-757 онгоцоор **2** удаа, төмөр замаар **2** удаа тус тус тээврийг зохион байгуулж нийт орлогийн хэмжээ **3 тэрбум төгрөгт** хүрч, өмнөх онтой харьцуулахад **2 ДАХИН** өсгөж чадлаа.



КАССЫН ПОС-ЫН СИСТЕМ

Аймгийн Шуудан үйлчилгээний газруудад кассын ПОС-ын системийг амжилттай нэвтрүүлээ.

01 дүгээр сарын 1-ний өдөр

01 дүгээр сарын 05-ны өдөр

06 дугаар сарын 28-ны өдөр

РИ-БРЕНДИНГ

Компанийн өнгө төрхийг шинэчилж, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангасан тохилог найрсаг орчинд шуудангийн үйлчилгээг үзүүлэх зорилгын хүрээнд шуудан үйлчилгээний **51 дүгээр салбарыг** 2018 оны 09 сарын 01-ний өдрөөс жишиг салбар, шуудан үйлчилгээний 20А салбарыг 2018 оны 06 сарын 28-нд VIP салбар болгон амжилттай шинэчиллээ.

06 дугаар сарын 02-ны өдөр

ЛОГИСТИК, ТЭЭВЭР ЗУУЧ

Орон нутгийн ачаа тээвэр, логистикийн үйлчилгээг өргөжүүлэх ажлын хүрээнд 2-р улирлаас эхлэн Дархан, Эрдэнэт, Булган, Дундговь чиглэлд тогтмол тээврийн үйлчилгээг амжилттай эхлүүлээ.



“НЭГ ЗОРИЛГО-НЭГ БАГ”

Компанийн бодлого, үйл ажиллагааны шинэчлэл, Эрхэм зорилго, Алсын хараа, Үнэт зүйлсийг нийт ажилтнуудад сурталчилан таниулах, ажилтнуудыг нэг зорилгод уриалан нэгтгэх ХУРЛЫГ 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдөр зохион байгууллаа

05 дугаар сарын 18-ны өдөр

06 дугаар сарын 29-ний өдөр

ГААЛИЙН БҮРТГЭГДСЭН МЭРГЭЖИЛТЭН

Гадаад шуудангийн үйлчилгээг хурдан, шуурхай болгох, компанийн орлогын шинэ эх үүсвэрийг нэмэгдүүлэх хүрээнд гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн бэлтгэж, боловсон хүчний нөөцөө бэхжүүлсэн.



5C МЕНЕЖМЕНТИЙГ НЭВТРҮҮЛЛЭЭ.

5C менежментийг хэрэгжүүлж **5C**-ийн аудиторудын багийг 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр байгуулж Ажлын байрны эмх цэгц, зохион байгуулалтыг сайжруулах **5C**-ийн стандартыг оффисын ажлын байранд нэвтрүүлж, 2018 оны 09 дүгээр сарын 10-наас **1C, 2C, 3C**-ийн аянг зохион байгууллаа.

04 дүгээр сарын 18-ны өдөр

10 дугаар сарын 02-ны өдөр

06 дугаар сарын 30-ны өдөр

“ICT EXPO 2017” ДИЖИТАЛ ХӨГЖИЛД ХАМТДАА

үзэсгэлэнд амжилттай оролцож бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдээлэл өгөн урамшууллын купоныг гаргаж хурдан шуурхай үйлчилгээг иргэдэд үзүүлж ажиллалаа.



ГААЛИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ТЭЭВЭР ЗУУЧ

БНХАУ-ын Эрээн хот - Улаанбаатар чиглэлд гүний гаалийн итгэмжлэгдсэн тээврийн үйлчилгээг захиалгын дагуу үзүүлж эхэлсэн.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ

компанийн 2017 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тухай хувьцаа эзэмшигчдэд танилцуулж, ногдол ашгийг 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ҮЦТХТөөр дамжуулан хувьцаа эзэмшигчдэд олголоо

04 дүгээр сарын 30-ны өдөр



САЛБАРЫН СПОРТ НААДАМ

Харилцаа холбоо мэдээллийн технологийн салбарт жил болгон зохион байгуулагддаг спортын наадамд 2018 оны 05 дугаар сарын 07-ноос 13-ний өдрүүдэд амжилттай оролцож нийт багийн амжилтаар гуравдугаар байранд шалгарч хүрэл медал хүртлээ

05 дугаар сарын 13-ны өдөр

05 дугаар сарын 22-ны өдөр



IPS 2017

IPS 2017

Улс хоорондын шуудангийн илгээмжийн бүртгэл хяналтын IPS 2014 системийг IPS 2017 болгон шинэчиллээ.



МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ФОРУМ 20

Мега төслүүд ба төрийн өмчит компаниуд: Сайн засаглал ба хувьчлалын бодлого” Сэдэвт салбар хуралдааны модератораар “Монгол шуудан” компанийн гүйцэтгэх захирал **Б.Анхбаатар** оролцож санал бодлоо хуваалцлаа.

05 дугаар сарын 23-ны өдөр

ПОСТ НЭТ МОБАЙЛ АПП

Гар утасны аппликешн 3.0 хувилбарт шилжин, OFFLINE горимд гардуулалт хийдэг боллоо.

05 дугаар сарын 25-ны өдөр

11 дугаар сарын 26-ны өдөр

12 дугаар сарын 02-ны өдөр

12 дугаар сарын 02-ны өдөр

12 дугаар сарын 31-ны өдөр

10 дугаар сарын 02-ны өдөр

ХУР СИСТЕМИЙГ АМЖИЛТТАЙ НЭВТРҮҮЛЛЭЭ.

ХУР Цахим системд нэгдэж хөдөө орон нутагт “Цахим үйлчилгээний нэгдсэн төв”-үүдийг байгуулж орон нутгийн иргэдэд цахим үйлчилгээг үзүүлж Цаашид Монгол улсын бүх сумдад энэхүү төвийг байгуулахаар зорин ажиллаж байна.



КАЙЗЕН САНАЛЫН СИСТЕМ

Бүтээлч, шинэ санааг дэмжих тасралтгүй сайруулалтын “Кайзен саналын систем”-ийг 2018 оны 11 дугаар сарын 26-ны өдөр компанийн хэмжээнд нэвтрүүлж “САЙЖРУУЛЪЯ, САНААЧЛАЯ” кайзен саналын анхдугаар уралдааныг 2018 оны 11 дүгээр сарын 01-ээс 30-ны хооронд кайзен багуудын дунд зохион байгуулж нийт **185** кайзен саналыг хүлээн авлаа.



MY DELIVERY

Логистикийн бүртгэл, хяналтын “My Delivery” цогц системийг захиалан хийлгэж, 2018 оны 12 сараас эхлэн онлайн худалдааны хүргэлтийн үйлчилгээг амжилттай эхлүүлээ.



ТӨСЛИЙН УДИРДЛАГЫН СТАНДАРТ

Төслийн удирдлагын Олон Улсын стандарт (PMBOK), “Төслийн удирдлагын арга зүйн заавар” ISO 21500 стандартын аргачлалаар боловсруулсан.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Компанийн ажилтнуудын орон сууц худалдан авах, орон сууцны нөхцлөө сайжруулах, хувийн орон сууц барих болон орон сууцны зээлээ төлөхөд дэмжлэг үзүүлэх зорилгоор ажлын амжилт гаргасан, тогтвор суурьшилтай ажилласан **20 ажилтанд** нийт **100 сая** төгрөгийн орон сууцны дэмжлэг үзүүлсэн



2018



Дэлхийн 192 улсад
шуудан солилцоо
хийдэг



21 аймаг 9 дүүрэг,
330 сум багт шуудан
солилцоо хийдэг



Нийт шуудан
солилцоо

8,037,239

НИЙТ 921 шууданч

Буухиа **179,239**



эмэгтэй
669

Эрэгтэй
252



Директ
шуудан

260,699



Дундаж цалин

Улаанбаатарт **877,7 төг**

Орон нутагт **346,3 төг**

Бичиг захидал

1,645,326



Илгээлт, боодол

478,034

Логистик тээвэр

280,834

Сонин, хэвлэл

5,193,107



Насны ангилал


20-55 НАС


Хөдөө орон нутагт

Улаанбаатар хотод

501 шууданч

420 шууданч





НЭГ.


УДИРДАГА, ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН
ХҮРЭЭНД

НЭГ. УДИРДАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

1.1. ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР

Өнөөдрийн байдлаар компанийн хэмжээнд шуудангийн үйлчилгээний **39** салбар, **22** аймаг, дүүргийн газар, **331** сумын салбарт нийт **921** хүн ажиллаж байна.

Нийт ажилчдын тоо




Ажиллах хүчний тоо



Хүйсийн харьцаагаар



Насны ангилал




**1.2.
НИЙГМИЙН
АСУУДЛЫН
ТАЛААР**

Цалин хөлс, урамшилт цалин

“Монгол шуудан” ХК, шуудангийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан 2017-2018 онд хэрэгжүүлэх хамтын гэрээний хэрэгжилтийг хангах хүрээнд 2017 оны үйл ажиллагаа, эдийн засгийн үзүүлэлтүүдийг үндэслэн, Улаанбаатар хотын шууданчдын цалинг 2018 оны 01 дугаар сарын 01-ний өдрөөс, аймгийн ШҮГ-ын шууданчдын цалинг 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс тус бүр нэмэгдүүлэв

 **Цалингийн харьцуулалт 2017-2018 он/мян**



Нийт ажилтнуудын дундаж цалинг сүүлийн 2 жилээр харьцуулахад, Улаанбаатар хотын ажилтнуудын дундаж цалин 2017 онд **746,5** мянган төгрөг байсан бол 2018 онд **877,7** мянган төгрөг болж, **1,18** хувиар, аймгийн ШҮГ-ын ажилтнуудын дундаж цалин 2017 онд **326,9** мянган төгрөг байсан бол 2018 онд **346,3** мянган төгрөг болж, **1,06** хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

**1.3.
ОЛОН
НИЙТИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЛААР**

“Орон нутгийн удирдах ажилтны зөвлөлгөөн-2018” Улаанбаатар хотод 2018 оны 02 дугаар сарын 23-26-ны өдрүүдэд амжилттай болж өндөрлөлөө. Уг арга хэмжээ нь аймгуудын ШҮГ-ын удирдлагуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэхийн зэрэгцээ тэдний бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэн, харилцан туршлага солилцуулсанаар тэдэнд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх, орлогоо хэрхэн нэмэгдүүлэх тухай арга замыг хайж олоход туслалцаа үзүүлж чадсан үр дүнтэй ажил боллоо.

Нийгмийн хариуцлага

“World Learning” төрийн бус байгууллагатай хамтран “Ил топ байдал залуусын нүдээр” төсөлд нэгдэж, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад зориулсан авлига, ил тод байдлын тухай сургалтын хэрэглэгдэхүүнийг Монгол орон даяар, аймаг сумдын 730 гаруй сургуульд үнэ төлбөргүй хүргэхээр хамтран ажиллах санамж бичгийг үзэглэлээ.

Орон сууцны буцалтгүй тусламж 20 ажилтанд тус бүр 5 сая төгрөгийг олголоо.

>
Орон сууцны
буцалтгүй
тусламжийн
батлаж
гардуулах үеэр



Дэлхийн ноён оргил Эверестэд гарсан уулын спортын ОУХМ Ж.Бямбасүрэн ба түүний багийнханы авиралтанд шаардлагатай зүйлсийг монгол улсаас буухиа шуудан /EMS/-ийн үйлчилгээгээр Эверестийн үндсэн отогт нь хүргэж гардууллаа.

“Хавдрын эсрэг хамтдаа” хандивын марк гаргав

“Монгол Шуудан” ХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд шуудангийн 1038 дахь сэдвийн маркийг “Хавдрын эсрэг хамтдаа” нэртэйгээр Хандивын марк гаргалаа. Тус марк нь нийт 30,000 ширхэг хэвлэгдсэн ба борлуулалтын үнийн дүнгээс ширхэг тутамд 200 төгрөгийг хавдрын эсрэг аянд зарцуулагдах юм.





ХОЁР.


ШУУДАНГИЙН СҮЛЖЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ,
ТЕХНОЛОГИЙН ТАСРАЛТГҮЙ ХЭВИЙН
АЖИЛЛАГААГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД

ХОЁР. ШУУДАНГИЙН СҮЛЖЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ, ТЕХНОЛОГИЙН ТАСРАЛТГҮЙ ХЭВИЙН АЖИЛЛАГААГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД


2.1. ШУУДАН СОЛИЛЦООНЫ БҮРТГЭЛ, СУДАЛГААНЫ ТАЛААР

Шуудангийн сүлжээг хөгжүүлэх, сүлжээний байнгын тасралтгүй хэвийн ажиллагааг хангах үйл ажиллагааны хүрээнд орох, гарах чиглэлд улс хоорондын шуудангийн агаарын тээврээр **40156 ширхэг** богц буюу **301750 кг**, газраар **749 ширхэг** богц буюу **4287.6 кг**, дотоодын шуудангийн агаарын тээврээр **5351 ширхэг** богц буюу **49647.7 кг**, хот хоорондын тээврээр **37028 ширхэг** богц буюу **76781.4 кг**, төмөр замаар **10123 ширхэг** богц буюу **34130.6 кг**, өөрийн тээврээр **4804 ширхэг** богц буюу **39766.6 кг**, Улаанбаатар хотын салбар хооронд **71731 ширхэг** богц буюу **469559 кг** шуудан хүлээн авч, солилцож, ялган боловсруулж гаргасан.


Улс хоорондын шуудан



Дотоод шуудан



Илгээмж тус бүрээр задалбал, буухиа шуудан 270787 ширхэг, бичиг захидал 1846512 ширхэг, илгээлт 54782 ширхэг, хэвлэл 5112120 ширхэгийг тус тус ялган боловсруулсан.


Солилцоо



2.2. ХҮРГЭЛТИЙН ЧИГЛЭЛ, МАРШРУТЫГ ОНОВЧТОЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ҮР АШИГТАЙ БОЛГОХ ТАЛААР

Галт тэрэгний цагийн хуваарьт өөрчлөлт орсонтой холбогдуулан Улаанбаатар-Сайншанд-Улаанбаатар, Улаанбаатар-Замын-Үүд-Улаанбаатар чиглэлүүдийг нэгтгэн нэг чиглэл болгосноор **2 удаагийн** гарааг хэмнэж, уг **2 гарааг** нэмэлт болгон гаргаснаар зардлаа өсгөлгүйгээр шуудангийн давтамжийг Замын-Үүд суманд **2 удаа**, Багахангай, Говьсүмбэр, Даланжаргалан, Айраг, Сайншанд чиглэлд **2 удаагаар** нэмэгдүүлж дээрх чиглэлүүдэд шууданг **7 хоногт 4 удаа** хүргэж байна. Өөрийн тээвэр 2018 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс Даваа, Лхагва, Баасан гаригт Улаанбаатар хотоос Дархан-Уул, Орхон аймгийн чиглэлд явж эхэлсэнтэй холбогдуулан хот хоорондын тээврээр явж байгаа зам дагуух сум, суурингийн шууданг шилжүүлэн зохион байгуулсанаар **304** богцоор **2673.38 кг** шуудан хүргэсэн ба энэ чиглэлийн шуудангийн аюулгүй байдал, хяналтын хугацаа, хүргэлтийн чанар дээшилсэн.

2.3. ШУУДАНГИЙН ГАРДУУЛАЛТЫН ТАЛААР


Улс хоорондын болон дотоод шуудангийн гардуулалт

Төрөл	2017			2018		
	Илгээмжийн тоо	Гаалийн хяналтанд	Гардуулалт /%/	Илгээмжийн тоо	Гаалийн хяналтанд	Гардуулалт /%/
БУУХИА	27048	3050	95.31	25699	3034	96.42
ИЛГЭЭЛТ	16663	3635	99.34	15182	3166	95.71
БИЧИГ ЗАХИДАЛ	16727	598	92.96	32192	669	90.38
Нийт дүн	60438	7283	95.87	73073	6869	94.17



2.4.
ХЭРЭГЛЭГЧИЙН
ҮЙЛЧИЛГЭЭГ
ХАРИУЦАН
ГОМДОЛ,
ХОХИРЛЫГ
БАРАГДУУЛАХ
ТАЛААР

Хэрэглэгчийн үйлчилгээний лавлах төв нь харилцах утсаар **40745**, үйлчилгээний заалаар **1737**, сайтын чатаар **2418**, дотоод сүлжээгээр **609**, компанийн фэйсбүүк хуудсаар **984**, электрон шуудангаар **22**, бичгээр **162** лавлагаанд хариу өгч ажиллалаа.



Утсаар	87%
Үйлчилгээний заал	4%
Вэбсайт чат	5%
Дотоод сүлжээ	1%
Фэйсбук чат	1%
И-мэйл	0%
Бичгээр	1%

РӨНХИЙ
ПС ХООРОНДЫН
ЭЭМЖИЙН
АЗАР

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ





Үйлчилгээ

POST
SHOP

POST SHOP



ШУУДАНГИЙН
УЛАМЖЛАЛТ БОЛОН
УХААЛАГ ХАЙРЦАГ



УЛС ХООРОНДЫН
ШУУДАНГИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ



БИЧИГ
ЗАХИДАА,
БООДОЛ



ДОТООД,
ГАДААД ХЭВЭЗЭ
ЗАХИААГА



ШУУД
СУРТАЛЧИЛГАА/
ДИРЕКТ ШУУДАН



ШУУДАНГИЙН
АЧАА ТЭЭВЭР,
ТЭЭШ



ГИБРИД
ШУУДАН



БУУХИА
ШУУДАН



ЦАХИМ
ХУДАЛДАА



МАРК, ИД
ЗАХИДАЛЫН
ХУДАЛДАА



ИЛГЭЭЛТ



ХҮРГЭЛТ

Улаанбаатар

МОНГОЛ
ШУУДАН

POSTSHIP
ЭНЧИГ ХЭРЭГ • НОМ • В • АЯГ ДУУСГАЛ

ГУРАВ.

ШУУДАНГИЙН БҮТЭЭГДЭХҮҮН
ҮЙЛЧИЛГЭЭГ ИДЭВХЖҮҮЛЭХ АЖЛЫН
ХҮРЭЭНД

ГУРАВ. ШУУДАНГИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭГ ИДЭВХЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД

3.1.

КОМПАНИЙН ӨНГӨ ТӨРХИЙГ ШИНЭЧЛЭХ, БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭГ СУРТАЛЧЛАХ, ОЛОН НИЙТЭД ТАНИУЛАХ ТАЛААР

Ребрендингийн ажил

Ребрендингийн ажлын хүрээнд Дархан, Хөвсгөл, Өвөрхангай аймгуудын шуудангийн үйлчилгээний газар, Улаанбаатар хотын ШҮ-ний 51, 36, 49, 21 дүгээр салбаруудыг жишиг салбар болгох ажлыг эхлүүлж, план зураг болон төлөвлөгөөг гарган ажиллаж байна.

ШҮ-ний 51-р салбарын зураг >



3.2.

ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВ, ӨДӨРЛӨГ, ҮЗЭСГЭЛЭНГИЙН ТАЛААР

Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагаа

Төрөөс мэдээлэл технологийн талаар баримтлах бодлого болон Засгийн газрын хэрэг эрхлэх газраас төрийн байгууллагуудад дижитал шилжилт хийх тухай зөвлөмжтэй уялдуулан төрөөс иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээг шат дараатай цахимжуулах бодлогын хүрээнд Сүхбаатар аймгийн Дарьганга, Өмнөговь аймгийн Даланзадгад, Гурвантэс, Увс аймгийн Зүүнхангай, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумуудад “Цахим Үйлчилгээний Нэгдсэн Төв”-ийг байгуулсан. Энэхүү төслийн хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2019-2020 онд хэрэгжүүлэх **23 тэрбум** төгрөгийн төслийг боловсруулан батлуулж 2019 төсөвт **6 тэрбум** төгрөгийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэв



Төрийн цахим үйлчилгээг иргэдэд үзүүлэх төсөл боловсруулж УИХ-аар батлуулсан.



Үндэсний Дата төвтэй Төрийн мэдээлэл солилцооны **ХҮР системийг** ашиглах гэрээ байгуулав

Төрийн цахим үйлчилгээг иргэдэд хүргэх Жишиг салбарыг **Дарьганга (СҮ), Гурвантэс (ӨМ), Даланзадгад (ӨМ), Цэцэрлэг (ХӨ), Зүүнхангай (УВ)** сумуудад нэвтрүүлэв.



2019–2020 онд хэрэгжүүлэх **23 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалтыг** батлуулав

Сумын ард иргэд заавал хот суурин газар, аймгийн төв орж авдаг байсан төрийн үйлчилгээг өөрийн харьяа сумд байрших “Цахим Үйлчилгээний Нэгдсэн төв”-өөс шууд авах боломж бүрдэж байгаа юм

Цахим үйлчилгээний нэгдсэн төвөөр үйчлүүлэх иргэд зөвхөн өөрсдийн иргэний цахим үнэмлэх болон хурууны хээг уншуулан газар дээр нь, түргэн шуурхай, дараалал чирэгдэлгүйгээр: - “Төрсний бүртгэлийн лавлагаа”, - “Хуулийн этгээдийн лавлагаа”, - Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа” зэрэг иргэдэд тогтмол шаардагддаг **10** гаруй үйлчилгээг авах боломжтой.

Өдөрлөг, үзэсгэлэн, олон нийтийн арга хэмжээ


Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төрийн өмчийн ашиглалт, хяналтыг сайжруулах, үрашгийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, засаглал, нийгмийн хариуцлагыг олон нийтэд сурталчлах чиглэлээр “Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага-2018” өдөрлөгөөр шуудангийн үндсэн үйлчилгээ болон буухиа шуудан, гадаад паспорт, жолооны үнэмлэхний хүргэлтийн үйлчилгээний талаар сурталчиллаа.

>
Ерөнхий сайд
У.Хүрэлсүх,
гүйцэтгэх захирал
Б.Анхбаатарын
хамт

“Төрийн өмчийн
менежмент
ба нийгмийн
хариуцлага-2018 он”



>
“Төрийн өмчийн
менежмент ба нийгмийн
хариуцлага-2018 он”



ICT EXPO 2018 Үзэсгэлэнг Засгийн газрын тохируулагч агентлаг-Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас “Дижитал Хөгжилд Хамтдаа” уриан дор 12 дахь удаагаа зохион байгуулсан. Үзэсгэлэнгийн үеэр мэдээлэл технологийн салбарын хөгжлийн чиг хандлага, нийгэмд үзүүлж буй үр нөлөөллийн талаарх сэдвийн хүрээнд Форум зохион байгуулагдсан.

>
Чуулганы
тайзнаа



“Монголын эдийн засгийн чуулган-2018”-д оролцож, “Монголын эдийн засгийн чуулган-2018” цомыг гардан авлаа. Чуулганаар компанийн танилцуулга болон сурталчилгааны тарааж, сурталчилгаа хийлээ.



Павилоны зураг

Мэдээллийн технологид суурилсан өндөр бүтээмжтэй, олон нийтэд хүртээмжтэй, төр засгийн үйлчилгээ, төр хувийн хэвшлийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх, уялдаа холбоог сайжруулах, суудалгаанд суурилсан, үйлчилгээнд чиглэсэн, ухаалаг төрийн зарчмыг хэрэгжүүлэхэд зорилготой **ICT EXPO 2018** амжилттай оролцлоо.

3.3.

ШУУДАНГИЙН ҮНДСЭН НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ, ИДЭВХЖҮҮЛЭХ ТАЛААР

Бичиг захидлын үйлчилгээ

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газруудаас зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөгүүдийн үеэр хэрэглэгчдээр ил захидал, бичиг захидал үнэгүй бичүүлэн, нийт мянга орчим хэрэглэгчдэд шуудангийн үйл ажиллагааг танилцуулж, **500** гаруй ширхэг ил захидал, бичиг захидлыг үнэгүй бичүүлж хүлээн авлаа.

“Цаг хугацаагаар аялсан захидал” зохион бичлэгийн уралдааныг улс орон даяар зохион байгууллаа.



Ил захидлын өмнөх жилийн борлуулалтын харьцуулсан үзүүлэлтийг судлан, шинээр гарч буй ил захидлын зургийн санг бүрдүүлэх, сонгон шалгаруулалтыг хийж, цоо шинээр **64 ширхэг** ил захидлыг бүтээгдэхүүн болгох ажлыг хийж гүйцэтгэв.

An aerial night photograph of a city street. The street is filled with cars, their headlights and taillights creating a flow of light. Buildings of various heights and styles line the street, many with lights on inside. The overall scene is a vibrant, illuminated urban environment.

ДӨРӨВ.

ТЭЭВЭР ЗҮҮЧ, ЛОГИСТИКИЙН
АЖЛЫН ХҮРЭЭНД

ДӨРӨВ. ТЭЭВЭР ЗУУЧ, ЛОГИСТИКИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД

4.1.

ТРАНЗИТ ШУУДАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ, ШИНЭЭР СУВАГ НЭЭХ ТАЛААР

Транзит шуудангийн үйлчилгээнээс гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг зохион 2016 оны 08 дугаар сараас хойш бүрэн зогссон байсан уг үйлчилгээг дахин эхлүүлэх арга хэмжээг амжилттай авч хэрэгжүүлсэний үр дүнд 2018 онд транзит шуудангийн тээврийг БЭЭЖИН-УЛААНБААТАР-МОСКВА чиглэд агаараар буюу Бойнг-757 онгоцоор 2 удаа, төмөр замаар 2 удаа, автомашинаар **235** удаагийн тээврийг тус тус зохион байгуулан ажилласан.



>
ОХУ-ын
шуудангийн
төлөөлөгчийн
хамт

4.2.

ДОТООДЫН ЛОГИСТИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ӨРГӨЖҮҮЛЭХ ТАЛААР

2018 онд Замын-Үүд–Улаанбаатар–Замын-Үүд логистик үйлчилгээ, Транзит шуудангийн тээвэр, Улаанбаатар хот доторх хүргэлт, Автовокзалын тээшийн үйлчилгээ, Гаалийн зуучлалын үйлчилгээнээс гадна Орон нутаг (Дархан, Эрдэнэт, Булган, Дундговь)-ийн тээвэр, онлайн худалдааны хүргэлтийн үйлчилгээг шинээр нэвтрүүллээ.

Орон нутгийн тээвэр, логистикийн үйлчилгээ

Логистикийн үйлчилгээг өргөжүүлэх ажлын чухал хэсэг бол орон нутгийн ачаа тээврийн үйлчилгээ юм. Тухайн чиглэлийн орон нутаг, аймгуудын ШҮГ-тай хамтран хэрэгжүүлж үйл ажиллагааг тогтворжуулсан. Ирэх онд Баянхонгор, Өвөрхангай, Хэнтий, Дорнод аймгуудад өөрийн тээврээр шуудан, логистик тээврийн үйлчилгээг эхлүүлэхээр бэлтгэл ажил хангагдаад байна.



4.3.
ГААЛИЙН
ЗУУЧЛАЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭГ
ЭХЛҮҮЛЭХ
ТАЛААР

Гаалийн мэргэжилтэн бэлтгэх зорилгоор ГЕГ-аас зохион байгуулсан ГБМ-ийн сургалтанд мэргэжилтэн В.Баярбат, Замын Үүдийн логистикийн төвийн дарга Э.Сарантунгалаг, Сэлэнгэ аймгийн логистик менежер Ц.Золзаяа нарын 3 ажилтныг сургаж амжилттай төгсөж сертификат, үнэмлэх авсан.

4.4.
ЯЛГАН
БОЛОВСРУУЛАХ
ТӨВИЙГ
БАЙГУУЛАХ
БЭЛТГЭЛ АЖЛЫГ
ХАНГАХ ТАЛААР

Олон улсын шуудан Ялган боловсруулах төвийг бариж, байгуулах төсөл боловсруулан ХХМТГ, Нийслэлийн эрх бүхий байгууллагад, Засгийн газрын түвшинд танилцуулан дэмжүүллээ. Мөн тус барилгын газар болон бусад холбогдох зөвшөөрлийг авч, барилгын зураг төслийг боловсруулан 2019 онд барилгын ажлыг эхлүүлэхээр төлөвлөн холбогдох тендер, сонгон шалгаруулалтын бэлтгэж ажлыг хангаад байна.



>
Терминал агуулахын
ерөнхий төсөөлөл,
харагдах байдал



ТАВ.
МАРК, ҮНЭТ ЦААС

ТАВ. МАРК, ҮНЭТ ЦААСНЫ ТАЛААР

5.1. МАРКИЙН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ

“Монгол шуудан” ХК-ийн хөгжил дэвшилтэй “марк” зайлшгүй холбогддог. Марк бол шуудангийн үйлчилгээний үндсэн бүтээгдэхүүн юм. Монголын шуудан холбоо нь олон зуун жилийн түүхийг бүтээсэн боловч Ардын хувьсгал ялах хүртэл буюу 1924 он хүртэл өөрийн үндэсний маркгүй байжээ.

Харин 1924 онд анхны маркаа худалдаанд гаргаснаас хойш олон төрлийн марк бүтээж, эдгээр нь “Монгол шуудан”-гийн бүтээгдэхүүн болсоор ирсэн юм. Анхны марк гарснаас хойш 2018 оныг хүртэл **1039** гаруй сэдвийн **4121** гаруй нэр төрлийн марк худалдаанд гаргажээ.



2018 оны шинэ марк



1. НОХОЙ ЖИЛ

Гүйлгээнд гарсан огноо:

2018.01.05

Хэвлэсэн тоо: **20,000 сери**

Төв шуудангийн үйлчилгээний “А” заал



2. МУГТ, ОУХМ

БАДАМГАРАВЫН

ГАНГААМАА

Гүйлгээнд гарсан огноо:

2018.03.19

Хэвлэсэн тоо: **15,000 ширхэг**

Маркийн нээлт: ЗГХА, БТСГазарт



3. МОНГОЛ ҮНДЭСНИЙ

ИДЭЭ, УНДАА

Гүйлгээнд гарсан огноо:

2018.04.22

Хэвлэсэн тоо: **20,000 сери**

Маркийн нээлт: Марк сонирхогчдын клуб



4. Ц.ДАМДИНСҮРЭНГИЙН

ГЭР МУЗЕЙ

Гүйлгээнд гарсан огноо:

2018.05.04

Хэвлэсэн тоо: **12,000 ширхэг**

Маркийн нээлт: Монголын үндэсний номын сан /Бичиг үсгийн баяр-2018/



5. ХҮҮХДИЙН УРАН ЗУРАГ

Гүйлгээнд гарсан огноо:

2018.06.01

Хэвлэсэн тоо: **30,000 сери**

Маркийн нээлт: Төв шуудангийн үйлчилгээний “А” заал



6. МОНГОЛЧУУДЫН

БИЧИГ ҮСЭГ

Гүйлгээнд гарсан огноо:

2018.06.21

Хэвлэсэн тоо: **20,000 ширхэг**

Маркийн нээлт: Төв шуудангийн үйлчилгээний “А” заал



7. МОНГОЛ ОРНЫ ҮЗЭСГЭЛЭНТ ГАЗАР-1
Гүйлгээнд гарсан огноо: **2018.07.27**
Хэвлэсэн тоо: **12,000 сери**



8. ХАВДРЫН ЭСРЭГ ХАМТДАА
/Өглөгийн марк/
Гүйлгээнд гарсан огноо: **2018.09.28**
Хэвлэсэн тоо: 30,000 сери
Маркийн нээлт: Хавдар судлалын үндэсний төвд



9. МОНГОЛ УГСААТАН
Гүйлгээнд гарсан огноо: **2018.10.15**
Хэвлэсэн тоо: **30,000 сери**

Шинэ маркийн анхны өдрийн дугтуйнууд



НОХОЙ ЖИЛ
Хэвлэсэн тоо-**300 ширхэг**
МУГТ, ОУХМ

БАДАМГАРАВЫН ГАНГААМАА
Хэвлэсэн тоо-**600 ширхэг**

Ц.ДАМДИНСҮРЭНГИЙН ГЭР МУЗЕЙ
Хэвлэсэн тоо-**500 ширхэг**

МОНГОЛЧУУДЫН БИЧИГ ҮСЭГ
Хэвлэсэн тоо-**350 багц**

МОНГОЛ ҮНДЭСНИЙ ИДЭЭ, УНДАА
Хэвлэсэн тоо-**300 багц**

МОНГОЛ УГСААТАН
Хэвлэсэн тоо-**350 багц**

МОНГОЛ ОРНЫ ҮЗЭСГЭЛЭНТ ГАЗАР-1
Хэвлэсэн тоо-**300 багц**

ХҮҮХДИЙН УРАН ЗУРАГ
Хэвлэсэн тоо-**350 ширхэг**

ХАВДРЫН ЭСРЭГ ХАМТДАА
Хэвлэсэн тоо-**600 ширхэг**

Мөнгөний дугтуй шинэ загвар



5.2.

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТАЛААР

Дэлхийн шуудан холбооны програмист Э.Борын дэмжлэгтэйгээр улс хоорондын шуудангийн чанар, мэдээлэл солилцоо, бүртгэл хяналтын IPS-2017 системийг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлээ.

Кассын борлуулалтын системийг Улаанбаатар хот, аймгийн төвийн салбаруудад бүрэн нэвтрүүлсэн. И-худлдааны бараа бүтээгдэхүүний хүргэлт, гардуулалтын My Delivery системийг амжилттай нэвтрүүлж үйл ажиллагаандаа хэвшүүлээ.

Транзит үйлчилгээний мэдээлэл солилцоо, бүртгэл хяналтыг сайжруулах зорилгоор улс хоорондын шуудангийн мэдээлэл солилцох ITMATT системийг туршиж хэрэгжүүлж эхлэв.

Үндэсний Дата төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулан Төрийн цахим үйлчилгээг хөдөө орон нутгийн иргэдэд зардал, чирэгдэл багатайгаар шуудангийн үндсэн сүлжээгээр дамжуулан хүргэх боломжийг бүрдүүлэв.

Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн төв байгуулах төслийн хүрээнд алслагдсан сум, багийн шуудангийн салбаруудын интернетийн урсгалыг нэмэгдүүлэх, бүх сумдыг нэгдсэн сүлжээнд холбох, дэд бүтцийг байгуулах ажлыг эхлүүлээ.

Шуудангийн гардуулалтын чанаржуулах, мэдээлэл солилцоог боловсронгуй болгох зорилгоор шуудангийн гардуулалтын аппликешныг шинэчлэн Online болон Offline горимд мэдээлэл дамжуулдаг боллоо.

Шуудангийн аюулгүй байдлыг хангах, шуудангийн салбаруудын өдөр тутмын үйл ажиллагааг хянах зорилгоор Улаанбаатар хотын болон аймгийн шуудангийн салбаруудыг хяналтын камераар хангав.

Орчин үеийн мэдээллийн технологийн хөгжлийг уламжлалт шуудангийн үйлчилгээтэй уялдуулан харилцагч байгууллагуудын яаралтай зэрэглэлийн шууданг цахим хэлбэрээр дамжуулах Гибрид шуудангийн үйлчилгээг өргөжүүлэн, хөгжүүлж байна.

Улс хоорондын шуудангийн мэдээлэл солилцооны IPS-системийг Дотоод шуудангийн бүртгэл хяналтын PostNet-V3 системтэй мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлснээр хэрэгчид www.mongolpost.mn сайтаар шуудангаа хянах боломжтой боллоо.



Дэлхийн шуудан холбооны програмист Э.Борын дэмжлэгтэйгээр улс хоорондын шуудангийн чанар, мэдээлэл солилцоо, бүртгэл хяналтын IPS-2017 системийг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлээ. Түүнчлэн кассын /POS/ системийг Улаанбаатар хот, аймгийн төвийн салбаруудад бүрэн нэвтрүүлсэн.


<
Гүйцэтгэх захирал
Б.Анхбаатар
Дэлхийн шуудан
холбооны
програмист
Э.Борын хамт

5.3. АВТО БААЗЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Үндсэн үйлчилгээг хөгжүүлэх зорилгын хүрээнд Улаанбаатар хотын Автопаркийн шинэчлэл хийж, хотын доторх автомашинтай хүргэлтийн үйлчилгээг эхлүүллээ.

>
Hyundai porter
маркийн 10
ширхэг
авто машин
хүлээн авч
байгаа нь





САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

II. ХАВСРАЛТ

СОЛИЛЦОНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1.1. КОМПАНИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2015 он	2016 он	2017 он	2018 он
Нийт солилцоо	1,610,819	1,571,830	1,757,660	2,302,599
Дотоод	1,090,199	1,102,770	1,288,531	1,590,703
Бичиг захидал	1,040,995	1,050,051	1,122,595	1,512,814
Боодол	25,944	28,554	46,054	55,928
Илгээлт	23,260	24,165	24,882	21,961
Улс хооронд	520,620	469,060	469,129	711,896
Улс хооронд Гарах	263,493	230,098	204,502	177,930
Улс хооронд Орох	257,127	238,962	264,627	533,966

Нийт солилцоо 2018 онд өмнөх жилээс **31.00** хувиар өссөн.

Нийт солилцоо




Компанийн нийт солилцооны үзүүлэлтүүд

Дотоод нийт солилцоо 2018 онд өмнөх жилээс **23.45** хувиар өссөн


Гадаад нийт солилцоо 2018 онд өмнөх жилээс **51.75** хувиар өссөн

Солилцоо


- Дотоод нийт солилцоо
- Улс хоорондын солилцоо



Гадаад гарах солилцоо 2018 онд өмнөх жилээс **-12.99** хувиар буурсан
 Гадаад орох солилцоо 2018 онд өмнөх жилээс **101.78** хувиар өссөн



Дотоодын солилцоо



1.2. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2018 онд жилийн эцсийн нийт орлого **15,473.9 сая** төгрөгт хүрч, 2017 оноос **13.2** хувиар өссөн байна. 2018 онд хил дамнасан и-худалдааны хүргэлтийн үйлчилгээний орлого **3,480.1 сая** төгрөг, хүргэлтийн үйлчилгээний орлого **1,141.9 сая** төгрөг, дотоод логистик үйлчилгээний орлого 745.3 сая төгрөгт тус тус хүрсэн нь энэхүү өсөлтийг бий болгоход голлон нөлөөлсөн байна.

2017 онд компани **1,224.1 сая** төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж байсан бол 2018 онд **1,560.3 сая** төгрөгийн ашигтай ажиллаж, цэвэр ашиг урьд оныхтой харьцуулахад 27.5 хувиар өссөн. Компанийн зардлын өсөлт 11.4 хувиар нэмэгдсэнд нийт ажилчдын цалинг **50 мянган** төгрөгөөр нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

Орлого, үр дүн /сая.төг/


Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	ӨСӨЛТ
Орлого	11,923.09	13,672.64	15,473.96	13.2%
Зардал	10,843.01	12,321.04	13,731.54	11.4%
Нийт ашиг	1,080.08	1,351.60	1,742.42	28.9%
Орлогын албан татвар	73.49	127.43	182.15	42.9%
Цэвэр ашиг	1,006.58	1,224.16	1,560.27	27.5%

Орлого, цэвэр ашиг /2014-2018 он сая.төг/

Дансны нэр	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Нийт орлого	11,022.71	10,094.19	11,923.10	13,672.63	15,473.96
Татварын дараах цэвэр ашиг	738.84	94.01	1,006.58	1,224.16	1,560.27


Орлого, цэвэр ашиг /2014-2018 он сая.төг/

- Нийт орлого
- Татварын дараах цэвэр ашиг




КОМПАНИЙН СҮҮЛИЙН ТАВАН ЖИЛИЙН ОРЛОГО, АШГИЙН ӨСӨЛТ

Нийт орлогын өсөлт



Татварын дараах цэвэр ашиг



1.3. КОМПАНИЙН 2018 ОНЫ САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Тус компанийн нийт активын хэмжээ 2018 оны жилийн эцэст **34,010.9 сая** төгрөгт хүрч урьд оныхоос 16.7 хувиар буурсан байна. Уг бууралтанд компанийн 2016 онд эхлүүлсэн БНХАУ-аас ОХУ руу чиглэсэн транзит үйлчилгээний төлбөр тооцоо болох өглөгийг төлсөн нь эргэлтийн хөрөнгө буурахад гол түлхэц болсон байна.

Нийт хөрөнгө /сая.төг/

Тайлангийн үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	Төгрөг	Өөрчлөлт
					Хувь
Нийт хөрөнгө	28,059.00	40,852.25	34,010.87	-6,841.38	-16.7%
Эргэлтийн хөрөнгө	19,749.90	32,355.63	25,637.25	-6,718.38	-20.8%
Эргэлтийн бус хөрөнгө	8,309.10	8,496.62	8,373.62	-123.00	-1.4%

Компанийн эргэлтийн хөрөнгө 2017 онд нийт хөрөнгийн **79.2** хувийг эзэлж байсан бол 2018 оны байдлаар **75.4** хувь болон буурч компанийн эрсдэл өндөртэй активийн хэмжээ багаслаа.

- Эргэлтийн хөрөнгө
- Эргэлтийн бус хөрөнгө



	2016 он	2017 он	2018 он
Эргэлтийн хөрөнгө	70.4%	79.2%	75.4%
Эргэлтийн бус хөрөнгө	29.6%	20.8%	24.6%


1.4. КОМПАНИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоол, Засгийн газрын 2015 оны **330** дугаар тогтоолын дагуу “Монгол шуудан” ТӨХК-ийн нийт хувьцааны **34** хувь буюу **33,859,363** ширхэг энгийн хувьцааг 2016 оны нэгдүгээр сарын 8-ны өдөр Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан арилжиж **6,263,982,155** төгрөгийг **256** хувьцаа эзэмшигчээс татан төвлөрүүлсэн байна.

Хувьцааны хоёрдогч зах зээл дээрх арилжаа 2018 онд нийт **199** өдрийн арилжаанд идэвхитэй байж, 2018 оны нэгдүгээр сарын 2-ны өдөр **600** төгрөгийн нээлтийн ханштайгаар эхэлж, 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр **684.03** төгрөгт хүрсэн нь 2018 он гарсанаар хамгийн дээд үнэ байлаа. Хувьцааны ханш анхны нэрлэсэн ханш болох **185** төгрөгөөс буюу хувьцаа эзэмшигчдийн анхны хөрөнгө оруулалтаас **3.69** дахин өсөөд байна. Компанийн Хөрөнгийн бирж дээрх үнэлгээ **59.75 тэрбум** төгрөгөөс оны эцсийн байдлаар **68.12 тэрбум** төгрөгт хүрээд байна. Өнгөрсөн 2018 онд компанийн хувьцааны ханшийн хэлбэлзлийг (хаалтын ханш) харвал:

Хувьцааны үнийн өөрчлөлт

2018.12.31



Компанийн үнэлгээ оны эцсийн байдлаар **68.12 тэрбум** төгрөг

эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж


Өнгөрсөн 2018 оны эхний 11 сарын байдлаар **659.93**-аас **510.00** төгрөг хүртэл буурсан хувьцааны үнэ 11 дүгээр сарын дунд үеэс огцом **34.1** хувийн өсөлтийг үзүүлж 2018 оны арилжааг **684.03** төгрөгт хүрч хаасан байна. Арилжааны тоо ширхэгийн хувьд өдөрт дунджаар **6,922 ширхэг** арилжаалагдсан байгаа нь өдөрт ойролцоогоор **4.0 сая** төгрөгийн, жилдээ **1,377,511** ширхэг хувьцааг **795.01 сая** төгрөгийн үнийн дүнтэйгээр хоёрдогч зах зээлийн арилжаа хийжээ.

Үзүүлэлт	2017 он	2018 он
Цэвэр ашиг /төг/	1,224,156,778.18	1,560,267,623.05
Нийт хувьцааны тоо	99,586,363	99,586,363
Нэгж хувьцааны үнэ /төг/	552.50	684.03
Нэгж хувьцааны өгөөж /EPS	12.3 төг	15.7 төг
Нэгж хувьцааны дансны үнэ	215.0	226.1
Нийт хөрөнгийн өгөөж /ROA/	0.0300	0.0459
Хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж /ROE/	0.0572	0.0693
Нийт хөрөнгийн эргэц /ROTA/	0.0331	0.0512


Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

2018 оны эцсийн байдлаар компанийн нийт хувьцааны **66** хувийг Төр, **25.18** хувийг Ард Санхүүгийн Нэгдэл, **8.82** хувийг бусад хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна.

- Төрийн өмч
- Ард Санхүүгийн нэгдэл
- Бусад



2017 он



2018 он



Аудитийн тайлан

2.1.
**МОНГОЛ ШУУДАН ХК
-ИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН
АУДИТ**

Төрийн Аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Монгол шуудан” ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

“Монгол шуудан” ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх санхүүгийн тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд нь материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй дүгнэлт гарсан.

Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант үе: 2017-12-31/2018-12-31

Үзүүлэлт	2017.12.31	2018.12.31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	26,659,316.320.01	17,267,083,063.60
Дансны авлага	2,791,724,588.39	5,788,142,997.08
Татвар, НДШ – ийн авлага	316,093.06	11,214,579.94
Бусад авлага	741,438,699.23	368,786,936.46
Бусад санхүүгийн хөрөнгө	350,000,000.00	.
Бараа материал	1,723,046,229.79	2,095,115,996.76
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	89,788,837.99	106,902,720.24
Бусад эргэлтийн хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгийн дүн	32,355,630,768.43	25,637,246,294.08
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	8,165,804,273.31	8,068,309,950.53
Биет бус хөрөнгө	330,310,766.78	304,812,810.22
Биологийн хөрөнгө	.	.
Урт хугацаат хөрөнгө оруулалт	500,000.00	500,000.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	8,496,615,040.09	8,373,622,760.75
Нийт хөрөнгийн дүн	40,852,245,808.57	34,010,869,054.83
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
ӨР ТӨЛБӨР		

БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Дансны өглөг	18,315,301,608.08	10,213,019,917.75
Цалингийн өглөг	442,279.64	0.29
Татварын өр	116,473,223.76	69,130,787.96
НДШ - ийн өглөг	10,546,707.79	0.00
Урьдчилж орсон орлого	848,689,798.32	989,525,152.12
Бусад богино хугацаат өр төлбөр	143,725,802.28	226,701,941.52
Богино хугацаат өр төлбөрийн дүн	19,435,179,419.86	11,498,377,799.63
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Урт хугацаат зээл	.	.
Урт хугацаат өр төлбөрийн дүн		
Нийт өр төлбөрийн дүн	19,435,179,419.86	11,498,377,799.63
ЭЗДИЙН ӨМЧ		
Өмч:- төрийн	6,572,700,000.00	6,572,700,000.00
- хувийн	3,385,936,300.00	3,385,936,300.00
- хувьцаат	.	.
Халаасны хувьцаа	.	.
Нэмж төлөгдсөн капитал	2,538,512,210.00	2,538,512,210.45
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,379,919,523.85	3,379,919,523.85
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	.	.
Эздийн өмчийн бусад хэсэг	2,710,106,959.73	2,710,106,959.73
Хуримтлагдсан ашиг	2,829,891,394.68	3,925,316,261.18
Эздийн өмчийн дүн	21,417,066,388.71	22,512,491,255.21
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	40,852,245,808.57	34,010,869,054.84

төгрөг

Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант үе: 2017-12-31/2018-12-31

Үзүүлэлт	2017.01.01	2017.12.31
Борлуулалтын орлого (цэвэр)	12,116,604,477.20	14,386,649,985.51
Борлуулалтын өртөг	11,150,35,8677.41	13,144,919,741.79
Нийт ашиг (алдагдал)	966,245,799.79	1,241,730,243.72
Түрээсийн орлого	101,000,000.00	107,973,100.29
Хүүний орлого	1,450,619,977.71	978,515,051.27
Ногдол ашгийн орлого	-	-
Эрхийн шимтгэлийн орлого	-	-
Бусад орлого	-	822,000.00
Борлуулалт, маркетингийн зардал	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	700,682,373.39	885,838,643.78

Санхүүгийн зардал	-	-
Бусад зардал	169,359,316.00	193,018,362.95
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-299,328,330.11	490,648,872.41
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	3,093,385.43	1,588,718.55
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	.	-
Бусад ашиг (алдагдал)	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,351,589,143.15	1,742,420,979.51
Орлогын татварын зардал	127,432,364.97	182,153,356.46
Татварын дараахь ашиг (алдагдал)	1,224,156,778.18	1,560,267,623.05
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,224,156,778.18	1,560,267,623.05
Бусад дэлгэрэнгүй орлого		-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
Бусад олз (гарз)	-	-
Орлогын нийт дүн	-	-
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	1,224,156,778.18	1,560,267,623.05

төгрөг

Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант үе: 2017-12-31/2018-12-31_төгрөг

Үзүүлэлт	2017.12.31	2018.12.31
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
Мөнгөн орлогын дүн	51,837,355,502.17	73,491,611,313.80
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	11,319,362,827.26	10,722,574,208.53
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	78,217,316.45	26,889,263.00
Татаас, санхүүжилтийн орлого	3,168,063,448.94	2,949,578,177.70
ҮҮА-ны бусад мөнгөн орлого	37,271,711,909.52	59,792,569,664.57
Мөнгөн зарлагын дүн	38,766,556,000.67	84,212,951,149.0
Ажиллагчдад төлсөн	5,311,806,780.42	5,831,386,746.04
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,236,350,390.68	1,565,126,881.78
Бараа материал худалдан авахад төлсөн	1,337,472,506.90	1,840,637,770.90
Ашиглалтын зардалд төлсөн	1,696,531,086.10	1,521,112,339.01
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	733,484,374.92	2,057,024,179.61
Татварын байгууллагад төлсөн	1,000,226,694.72	1,074,823,569.66
Даатгалын төлбөрт төлсөн	39,380,686.45	47,385,763.25

төгрөг

“МОНГОЛ ШУУДАН” ХК-ийн үйл ажиллагааны тайлан

ҮҮА-ны бусад мөнгөн зарлага	27,411,303,480.48	70,275,453,898.75
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	13,070,799,501.50	-10,721,339,835.20
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
Мөнгөн орлогын дүн	7,266,090,374.95	1,544,805,269.79
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	4,850,000.0	0.0
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	666,800.0	0.0
Хүлээн авсан хүүний орлого	1,160,573,574.95	1,194,805,269.79
ХО бусад мөнгөн орлого	6,100,000,000.0	350,000,000.0
Мөнгөн зарлагын дүн	1,247,082,107.88	531,676,476.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	805,383,107.88	523,176,476.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	91,699,000.00	8,500,000.0
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.0	0.0
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	350,000,000.0	0.0
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,019,008,267.07	1,013,128,793.79
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.0	0.0
Мөнгөн орлогын дүн	0.0	0.0
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.0	0.0
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.0	0.0
Мөнгөн зарлагын дүн	303,855,696.56	442,596,781.13
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.0	0.0
Төлсөн ногдол ашиг	291,705,696.56	354,457,491.53
СҮА-ны бусад мөнгөн зарлага	12,150,000.00	88,139,289.60
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-303,855,696.56	-442,596,781.13
Валютын ханшийн зөрүү	-808,046,705.03	758,574,566.13
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	17,977,905,366.98	-9,392,233,256.41
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,681,410,953.03	26,659,316,320.01
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	26,659,316,320.01	17,267,083,063.60


төгрөг

Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант үе: 2017-12-31/2018-12-31

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2016 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	9,958,636,300.00	2,538,512,210.00	3,379,919,523.85	2,710,106,960.18	1,907,710,986.50	20,494,885,980.53
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						
Залруулсан үлдэгдэл						
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					1,224,156,778.18	1,224,156,778.18
Бусад дэлгэрэнгүй орлого						
Өмчид гарсан өөрчлөлт						
Зарласан ногдол ашиг					(301,976,370.00)	(301,976,370.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						
2017 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	9,958,636,300.00	2,538,512,210.00	3,379,919,523.85	2,710,106,960.18	2,829,891,394.68	21,417,066,388.71
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					(97,932,543.74)	(97,932,543.74)
Залруулсан үлдэгдэл						
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					1,560,267,623.05	1,560,267,623.05
Бусад дэлгэрэнгүй орлого						
Өмчид гарсан өөрчлөлт						
Зарласан ногдол ашиг					(366,910,212.81)	(366,910,212.81)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						
2018 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	9,958,636,300.00	2,538,512,210.00	3,379,919,523.85	2,710,106,960.18	3,925,316,261.18	22,512,491,255.21

төгрөг





“МОНГОЛ ШУУДАН” ХК

Сүхбаатарын талбай-9, ЧД, I хороо, Энхтайвны өргөн чөлөө, Ш/Х-1106,
Улаанбаатар-15160, Монгол улс

+ (976) 1800-1613

info@mongolpost.mn

www.mongolpost.mn